

Батлав.

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын дарга

/ А.Энхбат /

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн

“Би Ти Девелопмент” ХХК-ийн захирал

/ Х.Туяа /

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИХ MV-008469
ТООТ “ӨМНӨТ ХАР-АЙРАГИЙН ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД АРГААР
АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-008469 /

/ АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 6414877 /

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн

/ /

Боловсруулсан:

“Би Ти Девелопмент” ХХК-ийн
Геологич

/ Ю.Туяацэцэг /

2024 он

Агуулга

1.1	Төслийн танилцуулга.....	4
1.2	Төсөл хэрэгжих нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	14
1.3	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	24
1.4	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	27
1.5	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	28
1.6	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	31
1.7	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	31
1.8	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	32
1.9	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	33
1.10	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	34
1.11	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	36
1.12	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	37
1.13	БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	40
	БОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөнд тусгасан	
	БОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөнд тусгасан	
1.14	БОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	40

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.	Техник эдийн засгийн үндэслэл.....	4
Хүснэгт 2.	Төслийн талбайн байршлын газарзүйн солбилцол.....	4
Хүснэгт 3.	Далд уурхайн календарчилсан төлөвлөгөө /уулын ажлын хэмжээгээр/	5
Хүснэгт 4.	Ус хэрэглээ, жилээр	10
Хүснэгт 5.	Тэсрэх бодисын техникийн үзүүлэлт.....	10
Хүснэгт 6.	Тэсрэх бодисын хэрэглээ	10
Хүснэгт 7.	Эдийн засгийн үр ашгийн тооцоо	11
Хүснэгт 8.	Шатах тослох материал.....	13
Хүснэгт 9.	Үйлдвэрлэлийн хаягдал, бохирдол	13
Хүснэгт 10.	Хүдрийн бохирдлын дундаж хэмжээ	14
Хүснэгт 11.	Усны химийн шинжилгээний дүн (Хяналтын цооног)	20
Хүснэгт 12.	Төслөөс байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ.....	25
Хүснэгт 13.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал, төгрөгөөр ...	27
Хүснэгт 14.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	28
Хүснэгт 15.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	31
Хүснэгт 16.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	31
Хүснэгт 17.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	33
Хүснэгт 18.	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	34
Хүснэгт 19.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	36
Хүснэгт 20.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	37
Хүснэгт 21.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	40
Хүснэгт 22.	БОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	40

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн байршил	5
Зураг 2. Далд уурхайн хүдэр хоршоолох ашиглалтын систем	6
Зураг 3. Өмнөт Хар-Айрагийн хайлуур жоншны ордын хүдрийг гар аргаар ялгах схем	6
Зураг 4. Ордын төлөвлөлтийн дэвсгэр зураг	8
Зураг 5. MV-008469 ашиглалтын талбай, байрзүйн зураг.....	15
Зураг 6. “Өмнөт хар айраг” нэртэй MV-008469 талбайн дурсгал	23
Зураг 7. Нөхөн сэргээлт хийх талбайн сансарын зураг.....	32

1.1 Төслийн танилцуулга

Төслийн нэр: Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших "Өмнөт Хар-Айраг" хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах

Төсөл хэрэгжүүлэгч: "Би Ти Девелопмент" ХХК

- Улсын бүртгэлийн дугаар: 9011797002
- Регистрийн дугаар: 6414877
- Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар, 3-р хороо, 5 хороолол, хд37, 49 тоот
- Утас: 976-99096782; 88008632

Хүснэгт 1. Техник эдийн засгийн үндэслэл

Ордын геологийн (B+C) нөөц:	Хайлуур жоншны хүдэр: 151.15 мян.тн
Далд уурхайн олборлолтод өртөх геологийн (B+C) нөөц:	Хайлуур жоншны хүдэр: 123.8 мян.тн
Ордын үйлдвэрлэлийн нөөц:	Хайлуур жоншны хүдэр: 112.2 мян.тн
Далд уурхайн жилийн хүчин чадал:	Хайлуур жоншны хүдэр: 25.0 мян.тн
Ордын ашиглалтын хугацаа:	5 жил


Төслийн байршил: MV-008469 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь Айраг сумын нутаг дэвсгэр L-49-75 хавтгай дээр, Хайртын уурхайн зүүн талд, Улаанбаатар хотоос зүүн урагш, төмөр замаас 310 км зайд, Айраг төмөр замын өртөөнөөс 8.5 км зайд оршино.

Өмнөт Хар-айраг хайлуур жоншны ордын талбай нь 76.08 гектар талбайг хамардаг. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбицолыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2. Төслийн талбайн байршлын газарзүйн солбилцол

Тусгай зөвшөөрлийн дугаар, талбайн хэмжээ	Эргэлтийн цэгүүд	Газарзүйн солбицол (WGS84)		Тэгш өнцгийн солбицол (WGS84-UTM49N)	
		Уртраг, У	Өргөрөг, Х	Х (м)	Ү (м)
MV-008469 76.08 гектар	1-2	109° 22' 32.73"	45° 46' 17.62"	5069949.685	373715.074
	2-3	109° 22' 32.73"	45° 46' 00.62"	5069425.040	373704.414
	3-4	109° 24' 26.73"	45° 46' 00.62"	5069375.502	376166.691
	4-5	109° 24' 26.73"	45° 46' 03.62"	5069468.086	376168.536
	5-6	109° 24' 01.73"	45° 46' 03.62"	5069478.866	375628.571
	6-7	109° 24' 01.73"	45° 46' 11.61"	5069725.449	375633.504
	7-1	109° 23' 01.73"	45° 46' 11.61"	5069751.513	374337.640

**Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт орших MV-008469 тоот
"Өмнөт Хар-Айрагийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах" төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**



Зураг 1. Төслийн байршил


Хүчин чадал: Уурхайн хүдэр олборлолтын жилийн хүчин чадал 25.0 мян.тн. Нийт 5 жилийн хугацаанд 112.2 мян.тн хайлуур жоншны хүдэр олборлоно.

Хүснэгт 3. Далд уурхайн календарчилсан төлөвлөгөө /уулын ажлын хэмжээгээр/

№	Жилийн хүчин чадал, тн		25.0 мян.тн/жил					Нийт	
			1	2	3	4	5		
1.	Ашиглалтын жил		1	2	3	4	5		
2.	Уурхайн ажиллах хугацаа, хон		258	258	258	258	258	1380	
3.	Уулын ажлын төрөл	УҮА	м ³	842.4	1067.4	0.0	0.0	0.0	1909.8
4.		УБА	м ³	1223.7	2190.7	990.6	1235.6	723.8	0.0
5.		Хүдэр нураалт	м ³	5162.3	5205.7	7506.6	7000.5	8125.2	67245.7
6.		Бүгд	м ³	7228.4	8463.8	8497.2	8236.1	8849.0	41274.5
7.	Хүдэр олборлолт		тн	12184.3	25000.0	25000.0	25000.0	25000.0	112184.3
8.	Малталтаар		тн	4899.5	5970.4	7211.9	5288.1	3013.6	26383.6
9.	Нураалтаар		тн	7284.8	19029.6	17788.1	19711.9	21986.4	85800.7


Төсөл хэрэгжүүлэх үе шат, ажлын горим: Далд уурхай нь хоногт 2 ээлжээр, ээлжинд 8 цагаар ажиллана. Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу жилд нийтээр амрах баяр ёслолын хоногийг хасаж, жилд 258 хоног ажиллахаар уурхайн ажиллах горимыг тооцсон болно.

Далд уурхайн ашиглалтын сонголт: Өмнөт Хар-Айрагийн хайлуур жоншны орд нь цахиуржсан флюоритын, бага карбонатлаг хүдэр байна. Хүдрийн биет нь 65-80° уналтай, ашиглалтын гүн нь 30-70 м, 2.0 м дундаж зузаантай байна. Ордын уул-геологийн нөхцлөөс хамааруулан хүдэр хоршоолох ашиглалтын системээр ашиглана.



Зураг 2. Далд уурхайн хүдэр хоршоолох ашиглалтын систем

Жонш ангилан ялгах хэсэгт хүдрийг шигшүүр дээр +50 мм-ийн хэсгийг ангилан дараа нь гар аргаар ФК-92, ФК-85, ФК-75 маркийн бүхэллэг жоншийг ялгаж таваарын бүтээгдэхүүний овоолго уруу зөөвөрлөн, үлдсэн -50 мм-ийн ангиллын жоншны хүдрийг гүйцээн боловсруулах зорилгоор бусад баяжуулах үйлдвэрүүдэд зах зээлийн үнээр нийлүүлнэ.



Зураг 3. Өмнөт Хар-Айрагийн хайлуур жоншны ордын хүдрийг гар аргаар ялгах схем

Гар аргаар ялгах хэсгээс жилд 12.0 мян.тн бүхэллэг жонш, 13.0 мян.тн бага агуулгатай хүдэр гаргана. Цаашид бага агуулгатай хүдрээ флотацийн аргаар баяжуулан өндөр

агуулгатай баяжмал гарган авах боломжтой боловч манай уурхайн хувьд флотацийн баяжуулах үйлдвэр барих нь эдийн засгийн хувьд ашиггүй тул бага агуулгатай хүдрээ бусад баяжуулах үйлдвэрт зах зээлийн ханшаар нийлүүлнэ.

Ордын бодитой В+С зэрэглэлээр нөөц тогтоогдсон I, II, хүдрийн биетүүд нь хоорондоо 650 орчим метрийн зайтай учир тус бүр 1 ширхэг босоо гол амаар нээж тус ордод олборлолтын ажлыг явуулна.

Гараар ялгах хэсгийн ажиллах горим, хүчин чадал: Гар ялгалтыг жилд 258 хоног, 8 цагаар 2 ээлжээр ажиллана. Гар аргаар нийт хүдрийн 53.6%-ийг ялгана. Түүнээс 48.0 %-г бүхэллэг жоншоор нь ялгаж авна. Үлдсэн 52.0% нь бага агуулгатай хүдрийн нөөц овоолгод хуримтлагдана.

Хоногт ялгах хүчин чадал: $Q_{\text{хон}} = \frac{Q}{n} = 25000/258 = 97.0\text{тн/хоног}$

Үүнд:

Q - жилийн тооцооны хүчин чадал, тн;

n - жилд ажиллах хоногийн тоо.

Цагийн хүчин чадал: $Q_{\text{цаг}} = \frac{Q_{\text{хон}}}{T \cdot t} = 97.0 / (2 \cdot 8 \cdot 0.88) = 7.6 \text{ тн/цаг}$

Үүнд:

m - ээлжийн тоо;

t - ээлжинд ажиллах цаг.


Ялгах хэсгийн хүчин чадал 7.6 тн/цаг байхад тоног төхөөрөмжийн хүчин чадал 9.5 тн/цаг байгаа нь уурхайн тоног төхөөрөмжүүдийн хүчин чадал хангалттай байгаа нь харагдаж байна.

Уурхайн барилга байгууламж. Уурхайн барилга байгууламж нь үйлдвэрлэлийн барилга байгууламж ба ажиллагсдын тосгон гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

Үйлдвэрлэлийн барилга байгууламж

- *Тэсрэх материалын агуулах.* Уурхайн тэсрэх бодисын жилийн дундаж хэрэглээнээс хамаарч ТБ-ын агуулах нь 10 тн-ын багтаамжтай байх бөгөөд энэ нь уурхайн 1 сарын хэрэглээг бүрэн хангана.
- *Автогарааш.* Уурхай дээр байнга ажиллах тоног төхөөрөмж нь уурхайн ачигч машин 1 ширхэг, тогтмол бус байх гадаад тээврийн автосамосвал 2 ширхэг, уурхайн бусад бага оврын ачааны машин 1 ширхэг, усалгааны машин 1 ширхэг, нийт 5 орчим машин байна.
- *Сэлбэг материалын агуулах.* Уурхайн тоног төхөөрөмжийн тоо, бүтцээс хамааруулан сэлбэг материалын агуулахын хэмжээг 40.0 м² хэмжээтэй төмөр рам, хөөсөнцөр дулаалга бүхий хөнгөн материалаар хийгдсэн контейнер байхаар төлөвлөсөн. Уулын механик тоног төхөөрөмж (перфоратор, сэнс, ачааны машин, утгуурт ачигч гэх мэт засвар техникийн үйлчилгээний урсгал засварыг ажиллаж байгаа байранд нь гүйцэтгэх бөгөөд шаардлагатай агрегат зангилгааг засварын цехэд засна. Шинээр хийх, сэргээн засварлах боломжтой эд ангийг бэлэн эд ангиар солих, их засварыг Айрагийн засварын цехэд гүйцэтгэнэ. Уурхайн тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангаж байхын тулд засвар техникийн үйлчилгээний газрын 36 м² талбай бүхий барилгыг токарь, ерөм, фрезерийн суурь машин, дугуй засварын аппарат, цахилгаан ба хийн гагнуурын аппаратаар тоноглоно.

Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших “Би Ти Девелопмент” ХХК-ийн MV-008469 тоот
ашигт малтмал ашиглах ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Өмнөд Хар-Айраг” нэртэй хайлуур жоншны ордын
Төлөвлөлтийн ерөнхий дэвсгэр зураг



Зураг 4. Ордын төлөвлөлтийн дэвсгэр зураг

Дэд бүтэц: Уг район нь Монголын хайлуур жоншны тархалтын бүсэд багтдаг бөгөөд дэд бүтэц сайн хөгжсөн районд хамаарагдана. Хамгийн ойрхон засаг захиргааны нэгж нь Дорноговь аймгийн Айраг сумын төв хүртэл 5.7 км зайтай ба энэ нь төмөр замын өртөөний дагуу байрлах жижгэвтэр суурин газрын тоонд орно.

- **Цахилгаан хангамж:** Далд уурхайн цахилгаан хангамжийг Айраг сумын 110/35 кВ-ийн дэд станцаас хангана. Тус дэд станцаас уурхай руу 5 км урттай 10 кВ-ийн өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам татаж уурхайн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангана. Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг 10/0.4кВ-ын трансформаторын дэд станцуудаар дамжуулан 0.4кВ-ын цахилгаан эрчим хүчээр хангана.

Цахилгаан хэрэглэгчид

- Далд уурхайн газрын дээрх хэрэглэгчид: ерөнхий агааржуулалтын вентилятор, компрессор, өргөх төхөөрөмж
 - Далд уурхайн газрын доорх хэрэглэгчид: ачигч, усны насос, бэхэлгээний машин, хэсэгчилсэн агааржуулалтын вентилятор, скрепер, гэрэлтүүлэгч
 - Ангилан ялгах хэсгийн хэрэглэгчид: бутлуур, тэжээгүүр, туузан дамжуулагч, шигшүүр, гэрэлтүүлэг
 - Тосгоны хэрэглэгчид: ажилчдын байр, цайны газар
 - Бусад хэрэглэгчид: засварын газар, ШТЦ, ТМ-ын агуулах
- **Зам харилцаа:** Өмнөт Хар-Айрагийн хайлуур жоншны орд нь Айраг сумын төвөөс урагш 5.7 км-ийн зайд, төмөр замын станцаас 8.5 км-ийн зайд Хайртын уурхайн зүүн талд оршино. Нийслэл Улаанбаатар-Зуунмод-Чойр-Сайншанд-Улаанбаатар чиглэлийн төмөр зам дагуу 310 км зайд байрлана.

Уурхайн тээвэр нь далд уурхайн дотоод тээвэр, уурхайн гадаргуугийн дотоод тээвэр гэсэн үндсэн 2 хэсгээс бүрдэнэ.

- Далд уурхайн дотоод тээвэр нь малталт нэвтрэлтийн мөргөцөг, ашиглалтын блокоос хоосон чулуулаг ба хүдрийг “блок (мөргөцөг) - тээврийн штрэк - квершлаг - босоо ам” гэсэн маршрутаар зөөвөрлөх, тээвэрлэх үүрэгтэй.
 - Уурхайн гадаргуугийн дотоод тээвэр нь далд уурхайгаас гарах уулын цулыг хоосон чулуулгийн овоолго ба хүдрийн түр агуулах хүртэл тээвэрлэнэ.
- **Харилцаа холбоо:** Төсөл хэрэгжих Айраг суманд Мобиком корпораци ХХК, Скайтел ХХК, Юнител ХХК, Жи-Мобайл ХХК-иудын үүрэн холбооны үйлчилгээ нэвтэрсэн бөгөөд хөдөлгөөнт интернэт, дата үйлчилгээгээр дамжуулан интернэт сүлжээнд холбогдох бүрэн боломжтой байна. Уурхайд нийт 10 ширхэг богино долгионы ба утсан аппарат суурилуулна.

Уурхай нь дор дурьдсан цэгүүдэд богино долгионы станц ба утсан аппарат байрлуулна. Үүнд:

- Газрын дээрх өргөх лебёдкины байранд болон лампны өрөөнд;
 - Шатах тослох материал, тэсрэх материал, харуулын байр, ангилан ялгах хэсэг дээр;
 - Газрын доор үндсэн малталтын клетний дэргэд, тэсрэх материалын агуулах, засварын цехийн байранд;
 - Үйлдвэрийн талбайд уурхайд дарга, ерөнхий инженерийн өрөөнд;
 - Уурхайн тосгонд уурхайн дарга, ерөнхий инженерийн байранд тус тус байна.
- **Дулаан хангамж:** Дулаан хангамжийн хувьд төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох боломжгүй тул цахилгаан эрчим хүч ашиглан дулаан хангамжийн асуудлыг шийдвэрлэнэ.
 - **Усан хангамж:** MV-008469 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд уртрагийн 109°23'14.38" өргөргийн 45°46'08.71" байршилд Оптималтек ХХК цооног өрөмдөж гаргасан байна. Хайгуулын шатанд ундныхаа усыг Айраг сумын төвийн гүний худгаас авч ашигласан.

- Цооногийн гүн 100м, усны тогтсон түвшин (статик) 39.0м, цооногийн ашиглалтын усны ундарга 4.8 л/с.
- **Усны чанар:** Тус талбайн гидрогеологийн цооногийн усанд хийсэн ШУА,ГГХ-ийн Усны шинжилгээний лабораторийн үр дүнгээр ус нь *Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн чанарын хувьд давсархаг, зөөлөвтөр ус байсан (шинжилгээг хавсралтад оруулав).*
 - **Усны хэрэглээ:** Төслийн үйл ажиллагааны явцад уурхайн гар аргаар баяжуулах технологи, өрөмдлөг хийх, замын тоосжилтыг дарах болон ажилчдын унд-ахуйд ус ашиглана.

Хүснэгт 4. Ус хэрэглээ, жилээр

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Усны хэрэглээ, л/с	Жилийн усны зарцуулалт, м ³
1.	Гар ялгалт	м ³	2.69	60062.4
2.	Өрөмдлөг хийх	м ³	0.027	619.2
3.	Замын усалгаа	м ³	0.0028	61.92
4.	Унд ахуй	м ³	0.076	1702.8
Нийт		м ³	2.79	62446.32
5 жилд		м ³		312231.6

- **Тэсрэх бодис:** Далд уурхайн тэсэлгээний ажилд *бортогот тэсрэх бодис эмульс* хэрэглэнэ. Тэсэлгээг галаар болон цахилгаанаар гүйцэтгэнэ.

Хүснэгт 5. Тэсрэх бодисын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ
1.	Патроны диаметр	мм	32
2.	Патроны урт	мм	340
3.	Жин	гр	300
4.	Нягт	гр/см ³	1.0
5.	Ажиллах чадвар	см ³	360-380
6.	Детонацийн хурд	км/сек	3.6-4.8

Хүснэгт 6. Тэсрэх бодисын хэрэглээ

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Үндсэн малталт				Бэлтгэл малталт			
			БА	ИАОМ	Квр1	Кам	Т.штр	Дучка	А.орт	Восс
1.	Тэсрэх бодисын тооцооны хувийн зарцуулалт	кг/м ³	2.0	2.2	2.2	2.2	2.2	2.5	2.2	2.4
2.	Нэг удаагийн тэсэлгээгээр хэрэглэгдэх тэсрэх бодисын тооцооны хэмжээ	кг	24.4	16.0	16.0	16.0	16.0	11.4	16.0	12.7
3.	Нэг удаагийн тэсэлгээгээр хэрэглэгдэх тэсрэх бодисын бодит хэмжээ	кг	22.8	17.1	17.1	17.1	17.1	12.6	16.2	15.0
4.	Тэсрэх бодисын бодит хувийн зарцуулалт	кг/м ³	1.9	2.3	2.3	2.3	2.3	2.7	2.2	2.8
5.	Нэвтрэлтийн нэг уртааш метрт ноогдох тэсрэх бодисын хэмжээ	кг/у.м	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.5	0.5	0.6

Эцсийн бүтээгдэхүүн, үр өгөөж:

Эцсийн бүтээгдэхүүн. Ангилян ялгаж хэсгээс ФК-92, ФК-85, ФК-75 маркийн бүхэллэг жоншийг Айраг сумын төмөр замын зөрлөг хүртэл тээвэрлэж төмөр замаар экспортод гаргаж борлуулна. Харин бага агуулгатай таваарын хүдрийг Даланжаргалан сумын нутагт орших баяжуулах үйлдвэрүүдэд тээвэрлэн хүргэж борлуулна.

Эдийн засгийн үр ашгийн тооцоо. Төслийн хугацаанд нийт ФК-92, ФК-85, ФК-75 маркийн бүхэллэг 53.85 мян.тн, бага агуулгатай жонш 58.34 мян.тн ангилян ялгаж борлуулна. ФК-92, ФК-85, ФК-75 агуулгатай жоншийг харгалзан 610, 520, 400мян.төг, ядуу агуулгатай жоншийг агуулгаас хамаарч 30мян.төг-р борлуулахаар тооцож оруулав. NPV=10 дээр 816.2 сая.төг, IRR=25.1%-тай байна.

Хүснэгт 7. Эдийн засгийн үр ашгийн тооцоо

№	Үзүүлэлтүүд	Х.нэгж	-	Ашиглалтын хугацаа					Нийт
				1	2	3	4	5	
1.	Жилд олборлох хүдрийн хэмжээ	мян.тн	-	12.2	25.0	25.0	25.0	25.0	112.18
2.	Жилд борлуулах бүхэллэг жонш ФК-92	мян.тн	-	0.9	1.8	1.8	1.8	1.8	7.85
3.	Жилд борлуулах бүхэллэг жонш ФК-85	мян.тн	-	1.2	2.4	2.4	2.4	2.4	10.66
4.	Жилд борлуулах бүхэллэг жонш ФК-75	мян.тн	-	3.8	7.9	7.9	7.9	7.9	35.34
5.	Жилд борлуулах бага агуулгатай хүдэр	мян.тн	-	6.3	13.0	13.0	13.0	13.0	58.34
6.	1 тн бүхэллэг жоншны үнэ ФК-92	мян.төг	-	610.0	610.0	610.0	610.0	610.0	-
7.	1 тн бүхэллэг жоншны үнэ ФК-85	мян.төг	-	520.0	520.0	520.0	520.0	520.0	-
8.	1 тн бүхэллэг жоншны үнэ ФК-75	мян.төг	-	400.0	400.0	400.0	400.0	400.0	-
9.	1 тн бага агуулгатай хүдрийн үнэ	мян.төг	-	30.0	30.0	30.0	30.0	30.0	-
10.	Борлуулалтын орлого /ЭРЭЭН/	Сая.төг	-	2657.4	5452.5	5452.5	5452.5	5452.5	24,467.39
11.	Борлуулалтын орлого /дотоодод/	Сая.төг	-	190.1	390.0	390.0	390.0	390.0	1,750.07
12.	Нийт борлуулалтын орлого	Сая.төг	-	2847.5	5842.5	5842.5	5842.5	5842.5	26,217.47
13.	Далд уурхайн зардал	Сая.төг	-	1653.9	1858.3	1866.6	1869.4	1841.8	9,089.95
14.	Бутлан ангилах хэсгийн зардал	Сая.төг	-	725.6	725.6	725.6	725.6	725.6	3,627.82
15.	Захиргаа аж ахуйн зардал	Сая.төг	-	263.6	263.6	263.6	263.6	263.6	1,317.96
16.	Гадаад тээвэр /1 вагон 1027300 төг/	Сая.төг	-	85.5	175.5	175.5	175.5	175.5	787.52
17.	Гадаад тээвэр /авто тээвэр/	Сая.төг	-	32.9	67.5	67.5	67.5	67.5	302.90
18.	НӨАТ	Сая.төг	-	284.7	584.3	584.3	584.3	584.3	2,621.75

*Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт орших MV-008469 тоот
"Өмнөт Хар-Айрагийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах" төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

№	Үзүүлэлтүүд	Х.нэгж	-	Ашиглалтын хугацаа					Нийт
				1	2	3	4	5	
19.	АМӨЯХАТатвар	Сая.төг	-	0.14	0.14	0.14	0.14	0.14	0.72
20.	Хаалт, нөхөн сэргээлтийн зардал	Сая.төг	-	52.4	52.4	52.4	52.4	52.4	262.21
21.	Замын асуудал, зам арчилгаатай холбоотой зардал	Сая.төг	-	10.0	10.0	10.0	10.0	10.0	50.00
22.	БОХ, хяналт шинжилгээ, мониторингийн зардал	Сая.төг	-	15.2	15.2	15.2	15.2	15.2	76.00
23.	АМНАТ, экспортлох //Эрээн 5+4.5%, ЖҮ ФК-85-360.0\$, ФК-75-300\$ 1\$-2800.0 төг/	Сая.төг	-	436.3	895.2	895.2	895.2	895.2	4,016.88
24.	АМНАТ, /дотоодод 5%/	Сая.төг	-	142.4	292.1	292.1	292.1	292.1	1,310.87
25.	Тусгай зөвшөөрлийн төлбөр	Сая.төг	-	1.65	1.65	1.65	1.65	1.65	8.27
26.	Ус ашигласаны төлбөр	Сая.төг	-	0.91	0.91	0.91	0.91	0.91	4.56
27.	Газрын төлбөр	Сая.төг	-	2.74	2.74	2.74	2.74	2.74	13.69
28.	Нийт ашиглалтын зардал	Сая.төг	-	3708.0	4945.0	4953.3	4956.2	4928.6	23491.11
29.	ЭХШ	Сая.төг	80.0	80.0	80.0	80.0	80.0	80.0	400.13
30.	Татварын өмнөх ашиг	Сая.төг	-	0.0	897.5	889.2	886.3	913.9	3586.89
31.	ААНОАТатвар	Сая.төг	-	0.0	89.7	88.9	88.6	91.4	358.69
32.	Татварын дараах цэвэр ашиг	Сая.төг	-	0.0	807.7	800.3	797.7	822.5	3228.20
33.	Хөрөнгө оруулалт	Сая.төг	-	1751.41				-	1751.41
34.	Бэлэн мөнгөний урсгал /Cash flow/	Сая.төг	-1751.41	80.0	887.7	880.3	877.7	902.6	3628.33
35.	Cash flow өссөн дүнгээр	Сая.төг	-1751.41	-1671.4	-783.6	96.6	974.4	1876.9	492.92
36.	Ирээдүйн мөнгөний өнөөгийн үнэ цэнэ NPV= 5%	Сая.төг	1256.88						
37.	Ирээдүйн мөнгөний өнөөгийн үнэ цэнэ NPV= 10%	Сая.төг	819.2						
38.	Ирээдүйн мөнгөний өнөөгийн үнэ цэнэ NPV= 15%	Сая.төг	451.14						
39.	Өгөөжийн дотоод норм, IRR	%	25.1%						
40.	Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа	Жил	2.9						

*Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт орших MV-008469 тоот
“Өмнөт Хар-Айрагийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах” төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

№	Үзүүлэлтүүд	Х.нэгж	-	Ашиглалтын хугацаа					Нийт
				1	2	3	4	5	
41.	1 тн хүдрийн бүрэн өөрийн өртөг	мян.төг	-	304.33	197.80	198.13	198.25	197.14	209.40

Хог хаягдал: Төслийн үйл ажиллагаатай холбоотой ахуйн хог хаягдал (Шингэн хаягдал, Хатуу хог хаягдал, Хийн хаягдал), үйлдвэрлэлийн хаягдал хог хаягдал үүснэ.

- Ахуйн хог хаягдал (шингэн хаягдал): Уурхайн тосгоны ажилчдын хэрэглээнээс ахуйн бохир ус гарна. Ахуйн бохир усыг цооногт хуримтлуулан, зөврөөр зайлуулна.
- Ахуйн хог хаягдал (хатуу хог хаягдал): Ажилчдын хотхоноос ахуйн гаралтай хатуу хог хаягдал гарна. Ахуйн хог хаягдалд хуванцар, хүнсний сав баглаа боодол, шил, лааз, цаас, хоол хүнсний үлдэгдэл орно. Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалах бөгөөд ОН-тай хийсэн гэрээний дагуу зайлуулна.
 - Хог хаягдлын тооцоо: Ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлын хэмжээ нь ажилтаны тооноос шууд хамааралтай өснө. Уурхайн нэг ээлжинд 50 хүн байна гэж үзвэл: хоногт дунджаар 25кг, жилд дунджаар 5тн ахуйн хатуу хог хаягдал (нэг ажилтнаас хоногт дунджаар 0.5 кг гэж тооцож).
- Хийн хаягдал. Уурхайн хүнд даацын машин техникийн хөдөлгүүрийн шаталтаас ялгарах утаа (агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулагч бодис) нь хийн хаягдал байна. Автомашины хөдөлгүүр нь химийн нэгдмэл хорт бодис ялгаруулах нэг төрлийн химийн реактор юм. Энэхүү химийн реактор хөдөлгүүрийн чанар хир муудсан байна, ялгаруулах хорт нэгдэл нь төдийн хирээр нэмэгддэг. Автомашины утаанаас Cu, Ni, Cd, Hg зэрэг шатахууны найрлагын үндсэн хам бүрдлүүд, тэдгээрээс гадна Pb, Zn, Mn зэрэг нэмэлт хольцын элемент, тэднийг агуулагч нэгдлүүд нь хүрээлэн буй орчны агаар, хөрс, усыг ихээр бохирдуулах нөхцөлтэй байдаг.
 - Шатах тослох материал. Шатахуун зарцуулалтыг тоног төхөөрөмж тус бүрээр авч үзвэл утгуурт ачигч 74304.0л/жил, аж ахуйн ачааны машин 3750.0л/жил, усалгааны машин 3750.0л/жил нийт 81804.00 л/жил шатахуун зарцуулна.

Хүснэгт 8. Шатах тослох материал

№	Тоног төхөөрөмж	Тоо	Хэмжих нэгж	Норм	Жилд ажиллах дундаж (цаг, км)	Түлшний хэрэглээ, л
1.	Утгуурт ачигч	1	л/100км	18	4128.0	74304.0
2.	Аж ахуйн ачааны машин	1	л/100км	15	25000.0	3750.0
3.	Усалгааны машин	1	л/100км	15	25000.0	3750.0
Нийт дүн		3	-	-	-	81804.00

— Үйлдвэрлэлийн хаягдал

Хүснэгт 9. Үйлдвэрлэлийн хаягдал, бохирдол

Үйлдвэрлэлийн хаягдал		Хаягдлын хэмжээ, м ³
Хүдрийн биет-1 ашиглалтын үеийн хаягдлын хэмжээ	Хүдрийн биетийн Бл-I-1 Блокын ашиглалтын үеийн хаягдал	8518.1 м ³
	Хүдрийн биетийн Бл-I-2 блокын ашиглалтын үеийн хаягдал	6070.1
	Хүдрийн биетийн Бл-I-3 блокын ашиглалтын үеийн хаягдал	3867.3
	Хүдрийн биетийн Бл-I-3 блокын ашиглалтын үеийн хаягдал	3659.1
Хүдрийн биет-2 ашиглалтын үеийн хаягдал	Хүдрийн биетийн Бл-II-1 Блокын ашиглалтын үеийн хаягдал	8518.1
	Хүдрийн биетийн Бл-II-2 Блокын ашиглалтын үеийн хаягдал	6070.1

хаягдлын хэмжээ	Хүдрийн биетийн Бл-II-3 Блокын ашиглалтын үеийн хаягдал	3867.3
	Хүдрийн биетийн Бл-II-4 Блокын ашиглалтын үеийн хаягдал	3659.1

Хүснэгт 10. Хүдрийн бохирдлын дундаж хэмжээ


Ашиглалтын блокийн нэр	Хүдрийн биетийн дундаж зузаан, м	Блокийн тоо, шир	Бохирдол, %
Бл-I-1	3.33	1	5.67
Бл-I-2	2.27	1	8.09
Бл-I-3	1.44	1	12.23
Бл-I-4	1.43	1	12.23
Нийт 1-р хүдрийн биет	2.11	1	8.65
Бл-II-1	2.19	1	8.38
Бл-II-2	2.22	1	8.26
Бл-II-3	1.82	1	9.89
Бл-II-4	1.88	1	9.63
Нийт 2-р хүдрийн биет	2.03	1	8.98
Нийт ордын хэмжээнд	2.07	1	8.83

Дээрх тооцооны үр дүнгээс харахад хүдрийн хаягдал ба бохирдлын хэмжээ (ордын дундаж үзүүлэлтээр) П=16.7 % ба Р=8.83 % болж байна.

- Аюултай хог хаягдал. 40 кг-ийн савалгаатай аммонийн нитрат ашиглавал жилд 45 ш орчим нийлэг уут хаягдал болон гарна. Мөн хаягдал дугуй, тос тосолгооны материал, тэдгээрийн сав баглаа боодол, арчих материалын хаягдал гарна. Эдгээр хаягдлыг ангилан, түр хадгалж, хаягдал хүлээн авах цэгүүдэд хүлээлгэн өгнө. Ингэхдээ Хог хаягдлын тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан журмыг мөрдлөг болгоно.

1.2 Төсөл хэрэгжих нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

Физик газарзүйн нөхцөл. MV-008469 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь физик газарзүйн хувьд намхан уул толгодорхог рельеф бүхий далайн түвшнээс дээш дундажаар 1200 м-т өргөгдсөн говь, тал хээрийн бүслэлд багтана. Монгол орны физик газарзүйн мужлалтаар говийн их мужийн умард говийн ухаа толгодот тал гэсэн тойрогт багтана. Байгалийн бүсийн хувьд цөлжүү хээрийн бүсэд оршдог. Энэ тойрогт ухаа гүвээт тал зонхилох боловч тойргын өмнөт хэсгээр 900-1900 м-ийн үнэмлэхүй өндөр бүхий Дэлгэрхангай, Их Шанхайн уул нурууд оршдог.



Зураг 5. MV-008469 ашиглалтын талбай, байрзүйн зурагт

Уур амьсгал. Төсөл хэрэгжих нутаг нь дулаан зунтай чийг дутмаг мужид багтана. Бүх нутгаар агаарын хэм харьцангуй жигд тархалттай байдаг. Ургамалшил тачирхан, чулуурхаг буюу элсэрхэг гадаргатай тул наранд халж агаарын хэмийг нилээд дээшлүүлдэг.

Агаар, хөрсний температур. Дорноговь аймгийн зүүн хэсгээр жилийн дундаж агаарын температур 5.50С, нутгийн хойд хэсгээр харьцангуй хүйтэн 0.3⁰С, бусад нутгаар 3.5-3.7⁰С дулаан байна. Жилийн хамгийн дулаан 7-р сарын дундаж агаарын температур нутгийн хойд талаар 18.7⁰С, зүүн хэсгээр 21.3⁰С, төв болон өмнөд хэсгээр 23.1-24.0⁰С дулаан байна. Дулааны улиралд 20-25⁰С хэм халах боловч 30⁰С ба түүнээс дээш хэм халах явдал жилд дундажаар 30-39 хоног тохиолдоно. Жилийн хамгийн хүйтэн 1-р сарын агаарын дундаж температур тус аймагт -15.3⁰С (Хөвсгөл станц)....-20.7⁰С (Чойр станц)-ын хооронд хэлбэлзэнэ. Сарын дундаж агаарын температурын дундаж квадрат хазайлт өвлийн саруудад 2.0-3.4⁰С, зуны саруудад 1.3-1.5⁰С тус тус байна. 11-р сараас 12-р сар хүртэл хөрсний дундаж температур -3.6⁰С-аас-13.2⁰С хүртэл буурдаг ба 3-р сараас 10-р сар хүртэлх хугацаанд 0.3⁰С-аас 29⁰С хүрдэг. Жилийн дундаж хөрсний гадаргын температур нутгийн хойд талаар 2.4⁰С, Хөвсгөл станц орчмоор хамгийн дулаан 7.5⁰С бусад нутгаар 5.0...6.0⁰С дулаан байна. Улирлын хөлдөлтийн явцын дундаж гүн шаварлаг хөрсөнд 1.5 метр, элсэрхэг хөрсөнд 1.9 метр, хайргархаг хөрсөнд 2.2 метр хүрдэг байна. Хөлдөлтийн гүн нь хөрсний төрөл, чийгийн агууламжаас хамааран янз бүр байх боловч ерөнхийдөө 2 метрээс хэтэрдэггүй.

Нарны цацраг. Төсөл хэрэгжих нутагт жилдээ дундажаар 3338 цаг нар гийгүүлнэ. Нар гийгүүлэх хугацаа өвөлдөө бага 256 цаг, зундаа их 309 цаг байна. Жилийн дундаж нийлбэр цацраг тус нутгаар 434.5Мдж/м² байна.

Агаарын чийгшил, хур тунадас. Төсөл хэрэгжих нутгийн хойд талаар жилдээ 193.8мм, зүүн өмнөд хэсгээр 128.7мм, бусад нутгаар 100.9-113.5мм хур тунадас унана. Хур тунадасны хэмжээ маш ядмаг юм. Энэ нь хойт мөсөн далайн болон Номхон далайн агаар нэвтрэн ирэх боломж муу байдаг, гол төлөв эх газрын эрс тэс уур амьсгалтай байдалтай холбоотой юм. Төсөл хэрэгжих нутгаар жилийн дундаж харьцангуй чийгшил нутгийн хойд хэсгээр 65%, бусад нутгаар 53-59 % байна. Жилийн дундаж дутагдал чийг нутгийн хойд

хэсгээр 4.7 гПа , өмнөд болон зүүн хэсгээр 5.8-6.6 гПа, бусад газраар 7.1-7.7 гПа байна. Жилийн дундаж усны уурын даралт 5.4-5.9 гПа байна.

Агаарын даралт, салхи. Дорноговь аймаг ерөнхийдөө тэгш талархаг нутагтай учир станцын түвшин дэх агаарын даралтын зөрөө багатай. Жилийн дундаж агаарын даралт 865.7-905.0гПа-ын хооронд хэлбэлзэнэ. Салхины жилийн дундаж хурд нутгийн зүүн өмнөд хэсэгт харьцангуй бага 2.9м/с, бусад хэсгээр 3.1-4.3м/с байна. Баруун болон баруун хойд чиглэлийн салхи зонхилдог. Баруун чиглэлийн салхины давтагдал нийт нутгаар 12.1-47.7%, салхины дундаж хурд нь 5.2-6.9м/с, хойд чиглэлийн давтагдал 11.3-40.6%, салхины дундаж хурд 4.4-6.3м/с тус тус байна. Замын-Үүдэд зүүнээс 11.7%-ийн давтагдалтай салхины гурав дахь зонхилох чиглэл ажиглагддаг нь орон нутгийн онцлогийг тод харуулж байна. Дорноговь нийт нутгаар манай орны бусад нутгаас жилийн туршид салхи ихтэй өвөлдөө ч төдийлэн салхины хурд буурдаггүй онцлогтой. Хамгийн хүчтэй салхи шуурга 3-р сарын сүүлчээс 4-р сард ихэвчлэн хойд болон баруун хойноос чиглэлтэйгээр салхилдаг.

Цаг агаарын үзэгдэл. Дорноговь аймгийн нутагт жилдээ 28.6-43.8 өдөр бороо, 14.2-23.2 өдөр цас, 0.1-1.0 өдөр мөндөр ордог. Дуу цахилгаан жилдээ 4.1-45.3 өдөр, цасан шуургатай өдөр жилдээ 4.7-11.8 өдөр, шороон шуургатай өдөр 16.4-68.2 өдөр тус тус ажиглагддаг байна. Шороон шуурга нь тус бүс нутгийн агаарын чанарт мэдэгдэхүйц нөлөөлөл үзүүлнэ. 4-р сард салхины дундаж хурд 5.5 м/сек байдаг. Хааяа салхи шуурга богино хугацаанд 40 м/сек хүрч шуурна.

Агаарын чанар. Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт цаг уурын ажиглалтын нийт 5 станц, 8 харуул хэвийн ажиллаж байна. Агаарын чанарыг хянах зорилгоор цаг уурын станцуудад суурин болон зөөврийн багажаар агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулагч бодис болох нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), азотын давхар исэл (NO₂), хүхэрлэг хий (SO₂), PM2.5 тоосонцор, PM10 тоосонцор, TSP нийт тоосны агууламжийг тодорхой хугацаанд хэмжин "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS 4585:2016 стандартын хүлцэх агууламжтай харьцуулан, үр дүнг гаргаж мэдээллийн сан үүсгэж байна. Дорноговь аймгийн Сайншанд сумын агаарын чанарын харуулын агаарт агуулагдах хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂)-ийн агууламжийг 7 хоногт 2 удаагийн давталттайгаар хэмждэг бөгөөд Сайншанд сумын агаарын чанарын 7 хоногийн мэдээ /2020.08.17-2020.08.24/-ний хэмжилтийн үр дүнгээр "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS 4585:2016 стандартын хүлцэх агууламжаас даваагүй, агаарын чанарын индекс Цэвэр, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байна.

Физик бохирдол. Төслийн явцад цацраг идэвхижлийн бохирдол, дуу чимээ үүснэ. *Физик бохирдлын эх үүсвэрт* тэсэлгээ, хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмж гэх мэт орно. Төслийн явцад богино хугацаанд шууд бус замаар дуу шуугианы бохирдол үүснэ. Ялангуяа уурхайн тоног төхөөрөмж, тэсэлгээний ажил, хүнд даацын машин механизмын эх үүсвэрээс үүдэлтэй механик шуугиан үүснэ. Тэслэлт хийхэд үүсч байгаа хэт их даралтын хүч нь тэрхүү энерги тэсэлгээний талбайгаас агаар мандлаар тархахдаа даралтын долгион хэлбэртэй тархдаг. Тэсрэлтийн үед даралтын долгионы хүч асар хурдтай нэмэгдэж, тархахдаа тэрхүү хүч нь маш аажмаар суларна. Тэгсээр олон удаа хэлбэлзсэний дараа анхны байдалдаа ортлоо буурна. Даралтын долгион нь хүний чихэнд сонсогдохуйц (дуу чимээ) ба хүний чихэнд үл сонсогдох (тархи доргих) гэсэн хоёр энергийн хүчээс бүрдэнэ. Дуу чимээний цухалдам, дургүйцам шинж чанар бол субъектив шинжтэй. Дуу чимээ саад болж байгаа эсэх нь голчлон тухайн хүн хэрхэн хүлээж авах, дуу чимээ хүлээн авсан орчин нөхцөл, тухайн зан чанар, үйл ажиллагааны хэлбэр, тухайн хүн дуу авианд хэр дассан зэргээс шалтгаалдаг. Дуу шуугиан нь давтамж, эрчим, ритмээсээ хамаарч хүний эрүүл мэндэд ашигтай (тайвшруулах, эмчилгээний) ба хортой (ядаргаа, цусны даралт ихэсгэх, бухимдал үүсгэх, сонсголын эрхтнийг гэмтээх, механик гэмтэл учруулах) нөлөө үзүүлнэ. ДЭМБ-ын баримталдаг чиг шугамын дагуу шөнийн дуу чимээ нь жилийн дундажаар 40 дБ (А)-ээс бага байх хэрэгтэй гэж санал болгодог байна.

Геологийн тогтоц¹. MV-008469 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэн тойрны районд судалгаа хангалттай сайн хийгдсэн бөгөөд судалгааны байдлаас үзвэл:

- Уг илрэлийг анх Хар-Айрагийн жоншны ордыг нээх үед илрүүлсэн. Анх 1957 онд А.Хратов нарын геологичидын баг Хэнтий, Дорноговь аймгуудад хийсэн 1:200000-ын зураглалын ажлын үед анх нээсэн бөгөөд 1964 онд Ю.М.Логинов 1:200000 масштабтай геологийн зураглалын ажил хийсэн.
- Чойрын экспедици (М.Хишигдэлгэр) 1973-76 онд хайгуулын ажил явуулсан. Н.Ягаан, А.Батхүү нарын хийсэн 1:10000- масштабтай зураглалын ажлын үед уг районы стратиграфийн комплекс ба интрузив чулуулгийн талаар тодорхойлсон байна.
- 1982 онд (Ч.Чимэддорж нар) ордын хайлуур жоншны хүдэржилтийн жигүүр болон гүн рүү нь үнэлгээ өгөх зорилгоор 8 суваг, 50-90 м гүнтэй 6 налуу цооног өрөмдсөн.

Өмнөд Хар-Айрагийн хүдрийн дүүргийн зүүн хэсгийг бүхэлд нь хамарсан хожуу рифейн хувирмал чулуулаг, дээд юра-доод цэрдийн цагаан цавын свитын суурилаг, дундлаг хүчиллэг найрлагатай вулканит, делюви-пролювийн дөрөвдөгчийн хуримтлал, түрүү палеозойн лейкократ, ягаан боржин судлын чулуулгууд голлон тархсан.

Давхарга зүй

Хожуу Рифейн тунамал-хувирмал зузаалаг /R₁₋₂ O_r/. талбайн зүүн, зүүн өмнөд хэсгээр баруун хойш, зүүн урагш сунасан нэг төрлийн моноклиналь атираа үүсгэж багавтар талбайд блоклог бүтэцтэй тархсан. Энд цахиурлаг занар, элсэн чулуу, шохойн чулууны салаавчилсан үелэл голлох ба үелэл дундаа микро атираажилт үүсгэж, хааяа кварцын 0.2-0.4 м өргөн судлуудаар хөндлөн зүсэгдсэн хөхөвтөр, үнсэн саарал өнгөтэй дунд мөхлөгтэй доломитожсон, гантигжсан шохойн чулуу хар хөх өнгийн хуудсархаг занар, дунд том ширхэгтэй элсэн чулууны үелэлээс бүрдэх ба үзэгдэх зузаан 0.5-1.3 км хүрнэ.

Дээд юра-доод цэрдийн вулканоген зузаалаг. Энэ нь талбайн зүүн хойд, хойд хэсгээр багавтар талбайд мөлгөрдүү оройтой хяр толгодын оройн хэсгээр тархах ба бараан саарал, нүх сүвэрхэг андезит-порфирит, базальт, ягаан цайвар өнгийн риолит, риодацит, тэдгээрийн туф, туффитээс голлон тогтоно. Вулканоген зузаалаг нь 400-500 м зузаантай, 10°-20°-н уналттай, хучаас маягийн структур үүсгэх ба өөр хоорондын фацын шилжилтийн хил заагтай.

Дөрөвдөгчийн хурдас. Орчин үеийн сэвсгэр хурдасны хуримтлал нь хяр толгодын бэл хормой хажуугаар 0.6-1.8 м хүртэл зузаантай элювии, делювии, пролювийн гарал үүсэлтэй хурдас тархсан. Энд цайвар саарал өнгийн элс, шавранцар голлох ба хагас мөлгөржсөн хэмхдэс материал 20-30% хүртэл агуулна. Орчин үеийн /QIV/ хуримтлал нь намхан толгодын хоорондох нарийн гуу жалгаар болон Цагаан үүдийн талын урд биеийн жижиг тойрмуудад үнсэн саарал, цагаан шаргал өнгөтэй шаварлаг хурдсаас бүрдэл болох бөгөөд хуримтлалын үелэл сайн ажиглагдана. Эргийн дагуух зүсэлтээс ажиглахад дунд нь 5-7 см-н зузаантай элс хайрганы нимгэн үелэл салаавчлан тогтоно.

Тектоник. Судалгааны талбайг арай том хүрээгээр авч үзвэл БХ-ЗУ ба ЗХ-БУ чиглэлтэй хагарлуудаар шилжин, зүймэл бүтэцтэй ажиглагдана. Хагарлуудын дагуу катаклазилт, роговикжилт, серицитжилт, лимонитжилтын хувирлууд нилээд ажиглагдах боловч нүдэнд харагдах онцгой хүдэржилтгүй юм. Тухайн талбайд сансрын болон агаарын зургийн тайлалаар тогтоогдсон мезозойн идэвхжилийн үеийн хагарлууд нь голдуу уртрагийн дагуу чиглэлтэй, шугаман байрлалтай, жижиг хотгоруудын захын хэсгээр огтолсон, сброс маягийн шилжилтүүд үүсгэсэн нь тогтоогджээ. Айрагийн хүдрийн зангилааны энэ районд хайлуур жоншны хүдэржилтийг мезозойн идэвхжилттэй холбон тайлбарладаг.

¹ ТЭЗҮ тайлангийн 14-17 хуу

Геоморфологи. MV-008469 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь тэгширмэл газар, уулс хоорондын хотос, уулын дундах хотгор дах элэгдлийн гаралтай өргөгдмөл гадаргын гүвээт толгодот болон гүвээт гадаргатай. Өмнөт Хар-Айрагийн талбайн хүдрийн биетүүд нь хожуу палеозойн лейкократ, ягаан боржин, судлын чулуулгууд, хожуу рифейн тунамал-хувирмал зузаалгийн хөхөвтөр, үнсэн саарал өнгөтэй занарт үүсэн хөгжжээ. Суваг малталт, цооногуудын үр дүнгээс үзэхэд хүдрийн биет нь тектоник эвдрэлийн бүс даган үүссэн цахир, серицит, цахиуржилт, гидротермаль хувирлыг дагасан цахир хайлуур жоншны судлын биетүүд юм.

Өмнөт Хар-Айрагийн талбайн хайлуур жоншны 1-р хүдрийн биет нь 240м-н урт, дунджаар 2м зузаантай цахир хайлуур жоншны судлын 2-р хүдрийн биет, 200м урт, 0.8-3.0м зузаантай зүүн үзүүрлүүгээ салаалсан линз хэлбэрийн цахир хайлуур жоншны хүдрийн биетүүдээс тогтох бөгөөд талбайн хэмжээнд 1-р биет нь баруун урдаас зүүн хойш сунаж тогтсон байна. 2-р хүдрийн биет нь зүүн хойш 45-600-н азимутаар сунаж тогтсон, уналын өнцөг 70-75° байдаг. 2-р хүдрийн биет нь зүүн хойш 50-600-н азимутаар сунаж тогтсон, уналын өнцөг 70-75°-н хооронд байна. Хүдрийн биетүүд нь хожуу палеозойн лейкократ, ягаан боржин, судлын чулуулгууд, хожуу рифейн тунамал-хувирмал зузаалгийн хөхөвтөр, үнсэн саарал өнгөтэй занар, үүсэн хөгжжээ.

Гадаргын ус. MV-008469 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд гадаргын ус байхгүй, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт багтана.

Дүүргийн гидрогеологийн нөхцөл. Өмнөт Хар-Айрагийн талбай нь Монгол улсын гидрогеологийн дүүрэгчлэлээр Өмнөд системийн Хөх усны нуурын ай савд хамаарагдана (Н.Жадамбаа. 2012).

Дүүргийн хэмжээнд өмнө хийгдсэн геологийн зураглал, геологи хайгуулын ажил, гидрогеологийн судалгааны ажлуудын мэдээлэлд үндэслэн дүүргийн хэмжээнд гидрогеологийн хувьд дараах биеэ даасан уст давхарга, газрын доорх усны бусад хуримтлалын төрлүүдийг ялгаж болох юм. Үүнд:

- Голоцен-плейстоцений сэвсгэр хурдас дахь уст давхарга (Q₁₋₂)
- Хожуу рифейн тунамал-хувирмал зузаалаг дахь алаг цоог тархалттай газрын доорх ус (R₁₋₂O_r)
- Хожуу палеозойн гүний чулуулгийн ан цавын бүсийн алаг цоог тархалттай ус (үрZ₂)

Голоцен-плейстоцений сэвсгэр хурдас дахь уст давхарга нь нам уулс, толгодын бэл хормой хажуу, намхан толгодын хоорондох нарийн гуу жалгаар болон жижиг нуур, тойрмуудын хотгорт тархана. Сэвсгэр хурдсын зузаан нь толгодын бэл хормойгоор 0.6-1.8м, гадаргуугийн намссан хэсгүүдээр 10м хүрдэг. Ус агуулагч чулуулаг нь янз бүрийн ширхэгтэй элс, ховроор шавраар дүүргэгдсэн хайрга, сайрган хурдас, хайр, сайр, шавранцар, элсэнцэр, элснээс бүрдэнэ. Уст давхаргын зузаан нь 2.6-3.1м.

Голоцен-плейстоцений сэвсгэр хурдас дахь уст давхаргын ус нь чөлөөт гадаргуутай, түрлэггүй, тогтонги түвшин нь 1.4-3.0м-т байрладаг. Хашаатын дэл, Сухайн харчит худаг Баруун сайн ус зэрэг худгууд байх ба ундарга нь 0.2-0.7 л/сек. Химийн найрлагаараа гидрокарбонат-хлори натри-кальцийн төрөлд хамаарах ба эрдэсжилт нь 0.8-1.0 г/л.

Уг уст давхарга нь өөрийн тархсан талбайд унасан хур тунадас, гипсометрийн хувьд дээр орших бусад уст цогцолборуудаас урсах усаар тэжээгдэн усаа ихэвчлэн ууршилтаар гипсометрийн хувьд доор орших бусад үе давхарга болон худгийн ус ашиглалтаар алдана.

Хөндийн бэлийн түр зуурын урсацтай голын хөндий сайрын пролювийн хурдсаар дамжин өнгөрөх зөөгдлийн өнгөний усыг нутгийн ардууд гар худаг гарган унд ахуй мал усалгаанд ашигладаг. Худгийн ус нь цэнгэг, ундарга нь 0.2л/с-ээс хэтэрдэггүй, агаарын хур тунадсаас шууд хамааралтай.

Хожуу рифейн тунамал-хувирмал зузаалаг дахь алаг цоог тархалттай газрын доорх ус нь Өмнөт Хар айрагийн талбайн хойд, зүүн хойд хэсгээр тархана. Ус агуулагч чулуулаг нь ан цавжсан хар саарал, цайвар хүрэн өнгийн элсэн чулуу, саарал аргиллит,

цахиуржсан занраас бүрдэнэ. Ан цавшилтын бүсийн зузаан нь 58-79м хүрдэг (ПНИИС 1976).

Газрын доорх ус нь 21.0м-ээс 38.0 м-ийн гүнд илрэх ба сул түрэлттэй, түрэлтийн хэмжээ 8м хүрдэг. Цооногийн ундарга 2.0л/с-ээс 8.0л/с хүрэх ба бууралт нь харгалзан 57.5 ба 11.60м, хувийн ундарга нь 0,035-0,69 л/с байна. Химийн найрлага, эрдэсжилт газрын доорх усны хөдөлгөөний горимоос хамааран харилцан адилгүй. Газрын доорх ус нь цэнгэг, сул давсархаг. Цэнгэг ус нь гидрокарбонат натрийн төрөлд хамаарах ба эрдэсжилт нь 0.57-0.77 г/л, ерөнхий хатуулаг нь 3.39-5.89мг-экв/л. Харин сул давсархаг ус нь гидрокарбонат-натрийн найрлагатай, эрдэсжилт 1.4-1.5 г/л, ерөнхий хатуулаг нь 1.87-3.83 мг-экв/л байна.

Алаг цоог тархалттай ус нь өөрийн тархсан талбайд унасан хур тунадас, гипсометрийн хувьд дээр орших бусад уст цогцолборуудаас урсах усаар тэжээгдэн усаа ихэвчлэн гипсометрийн хувьд доор орших бусад үе давхарга болон худгийн ус ашиглалтаар алдана.

Хожуу палеозойн гүний чулуулгийн ан цавын бүсийн алаг цоог тархалттай ус. Өмнөт Айрагийн талбайд болон талбайн урд хэсгээр өргөн тархана. Энэ ус хуримтлалын нэгжид хожуу палеозойн лейкократ боржин, тэдгээрийн судлын чулуулгуудыг энд хамруулж ялгасан болно. Хожуу палеозойн гүний чулуулаг нь жигд бус ан цавжсан, ан цавжилтын зэрэг харилцан адилгүй. Тектоник хагарлын дагуу ан цавжилтын зэрэг, тархалт илүү байдаг. Ан цавжилтын зузаан янз бүр, тектоникийн үйлчлэлээс шууд хамааралтай.

Газрын доорх ус нь ихэвчлэн чөлөөт гадаргуутай, түрлэггүй, зарим тохиолдолд ус үл нэвтрүүлэгч хурдсаар хучигдсан тохиолдолд түрлэгтэй байна. Өмнөт Айрагийн талбайд ойролцоо гүний чулуулагт 2 цооног өрөмдсөн байдаг. Эдгээр цооногуудын тогтонги түвшин нь 19.0-27.3 м-т байрлана. Ундарга нь 0.9-1.7 л/с, бууралт нь харгалзан 15.0 ба 5.3м. Уурхайн болон гар худаг байх боловч ундарга нь 0.3л/с-ээс хэтэрдэггүй.


Гүний чулуулгийн ан цавын бүсэд хуримтлагдсан ус нь гидрокарбонат-хлори натрийн найрлагатай, эрдэсжилт нь 0.8-3.2г/л. Эрдэсжилтийн өргөн хэлбээл нь ус хуримтлагдах геологи-гидрогеологийн нөхцөл, газрын доорх усны хөдөлгөөний горимтой холбоотой.

Тэжээгдлийн эх үүсвэр нь өөрийн тархалтын талбайд унах агаарын хур тунадас юм. Дээр тодорхойлолт өгсөн газрын доорх усны хуримтлалын нэгжүүдээс харахад тухайн дүүрэгт унд, ахуй, үйлдвэрлэлийн бага хэрэглээтэй ус хангамжийн газрын доорх усны эх үүсвэр нь хожуу рифейн тунамал-хувирмал зузаалаг дахь алаг цоог тархалттай газрын доорх ус юм гэж дүгнэж байна.

Гидрогеологийн хувьд ан цавын ус харьцангуй бага тархалттай боловч зэргэлдээх районд хийгдсэн судалгаа, геофизикийн судалгааны зарим үр дүнгээс үзвэл Рифейн тунамал-хувирмал зузаалагт гидрокарбонатлаг найрлагатай ан цавын ус зонхилох хандлагатай гэж үзжээ. Дөрөвдөгчийн хурдас нь 2.6-3.1 м-н гүнд хөрсний ус агуулах ба хатуулагаар дунд зэрэг, усны түвшин нь атмосферийн хүчин зүйлүүдээс хамаарч байнга хэлбэлзэлтэй байдаг ба энд цэвдэг үүсгэгчийг тогтоогоогүй байна. Гидрогеологийн дэд мужлалаар энэ талбай нь гүний ба бялхмал чулуулагт ан цавын, цэрд, дөрөвдөгчийн хурдсанд ан цавын ус агуулсан, бусад шинж чанараараа чөлөөт гадаргуутай түрэлтэй усны ангилалд хамаарна. Хашаатын дэл, Сухайн харчит худаг болон бусад уст цэгүүдийн ус нь 0.2-0.5 л/сек ундрагатай хатуулаг ихтэй харин палеозойн боржингийн ан цавын ус нь ундрага сайтай цэвэр усны эх үүсвэр байх бүрэн боломжтой. Айрагийн хүдрийн районы бусад уст цэгүүдтэй харьцуулахад энэ хэсэгт 0.3-0.5 г/л-н эрдэсжилтэй, 2.0-2.4 мг-/экв гидрокарбонат-натри магнийн найрлагатай усны нөөц байх бүрэн боломжтой гэж үзэж болно. Энэ районд ашиглалт явуулж байсан Хайртын уурхайгаас 80 м-ийн гүнд ус илэрсэн байдаг бөгөөд хайгуулын ажлын үед нэвтэрсэн 2 босоо амнаас хоёулангаас нь ус гарсан болно. Мөн тус ордоос 0.5 км-н зайд Алтатын уурхайн худаг байрлана. Айраг сумын төв дээр 3 ш гүний худаг үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хайгуулын шатанд ундныхаа усыг Айраг сумын төвийн гүний худгаас авч ашиглаж байжээ².

² ТЭЗҮ-ийн 90-92 хуу

Усны чанар. MV-008469 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн гидрогеологийн цооногийн усанд хийсэн ШУА,ГГХ-ийн Усны шинжилгээний лабораторийн үр дүнгээр ус нь Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн чанарын хувьд давсархаг, зөөлөвтөр ус байна.



Хүснэгт 11. Усны химийн шинжилгээний дүн (Хяналтын цооног)

Анион	1 дм ³ -д байгаа			Катион	1 дм ³ -д байгаа		
	мг	мг-экв	мг-экв/%		мг	мг-экв	мг-экв%
Cl-	56.8	1.60	12.2	Na++K+	209.3	9.10	69.2
SO4--	165.0	3.44	26.2	Ca++	44.1	2.20	16.7
NO2-	0.1	0.00	0.0	Mg++	21.9	1.80	13.7
NO3-	25.0	0.40	3.1	NH4+	0.5	0.03	0.2
CO3--	0.0	0.00	0.0	Fe++	0.0	0.00	0.0
HCO3-	469.7	7.70	58.6	Fe+++	0.3	0.02	0.1
Дүн	716.6	13.14	100.0	Дүн	276.1	13.14	100.0

<i>Анион катионуудын нийлбэр:</i>	992.7 мг/дм ³
<i>HCO3- ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр:</i>	757.8 мг/ дм ³
<i>Ерөнхий хатуулаг:</i>	4.00 мг-экв/ дм ³
<i>pH:</i>	7.64
<i>ЕС:</i>	1354 µS/см
<i>TDS:</i>	744 ppm
<i>Исэлдэх чанар:</i>	4.64 мг/ дм ³

Усны физик шинж чанар

<i>Тунгалаг:</i>	26см
<i>Үнэр:</i>	Үгүй
<i>Тунадас:</i>	Үгүй
<i>Өнгө:</i>	Сул шаргалдуу
<i>Амт:</i>	***
<i>Булингар:</i>	4.79 NTU

$$\text{Усны найрлагын томъёо } M1.0 \frac{HCO_3^- 59 SO_4^{2-} 26 Cl^- 12}{Na^{++} K^{+} 69 Ca^{2+} 17 Mg^{2+} 14}$$

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд томоохон уст давхарга байхгүй.

Хөрсөн бүрхэвч. MV-008469 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь өргөргийн хувьд говь цөлийн зааг нутгийг хамарч, д.т.дээш 1020-1040м өргөгдсөн хадархаг хөрс зонхилсон, гадаргуугийн хэрчигдэл ихтэй, бэсрэг цуваа нам уулсын хооронд элс, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хөрс зонхилно. Хөрсний төлөв байдал нь газарзүйн

орчин, хөрс үүсгэгч хүчин зүйлээс хамаарч 1 хэв шинжид багтах 3 өөр төрлийн хөрс тогтворжиж, Говийн бор хөрсний хэв шинж ноёлон тархсан байна³. Үүнээс сайр чулуурхаг карбонатгүй бор - *Amphi non carbonated campic soil*, карбонатлаг элсэн бор - *Amphi non carbonated Endo hyper skyletic calci soil* сайр чулуурхаг карбонатлаг элсэнцэр бор хөрсний төрөл тархжээ. Хөрс нь элс, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй бөгөөд энэ хөрс нь хүний шууд болон дам нөлөөлөлд хялбар өртдөг.

Инженер Геодези ХХК-ийн хөрс судлалын лабораторийн шинжилгээний үр дүнгээс:
Хөрсний агрохими-физик шинж чанар. Ордын талбайн хөрсний хими физикийн шинж чанар нь рН 6.7-8.0 буюу сул хүчилэгээс шүлтлэг урвалын орчинтой, давс 0.01-0.05% буюу багатай, карбонатлаг CO₂-ийн хэмжээ 0.00% буюу карбонатгүй, хөрсний зүсэлт 2-ын 47-63см гүнд 0.33% буюу сул карбонаттай, ялзмагийн агууламж 0.3-1.5% буюу ядмаг мөн шим тэжээлийн хөдөлгөөнт элементүүд P₂O₅ 1.0-2.6 мг/100гр, K₂O 2-23мг/100гр буюу багатай, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хөрс тархжээ.



Сайр чулуурхаг бор хөрс



Карбонатлаг элсэн бор хөрс



Сайр чулуурхаг бор хөрс

Дүгнэлт. Ордын талбайн шимт хөрсний зузаан нь 45°46'06.28" 109°22'38.98" координат орчимд 0-20см, 45°46'00.25" 109°24'07.24" координат орчимд 0-50см болон 45°45'50.92" 109°24'30.81" координат орчимд 0-15см зузаан шимт хөрстэй байна. Хөрсний үржил шимийг тодорхойлогч элементээр ядмаг, элсэн болон элсэнцэр ширхэгийн бүрэлдэхүүнтэй бор хөрс тархсан байна.

Хөрсний бохирдол. Төслийн талбайн хөрснөөс дээж авч Cr(хром), Pb(хар тугалга), Cd(кадми), Ni(никель), Zn(цайр), Cu(зэс) 6-н хүнд металлын агууламжийг "Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын, зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5850:2019" стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй харьцуулахад маш бага гарсан тул, хөрсний бохирдолгүй байна.

Ургамлан нөмрөг⁴. Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэр бүхэлдээ Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаардаг. Энэ бүс нутгийн хэмжээнд ургамлын аймаг, ургамалжлын судалгаа харьцангуй бага хийгдсэн байдаг. Ус чийг багатай, салхи ихтэй учир ургамлын бүрхүүл сийрэг байдаг. MV-008469 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь бүхэлдээ баглуур-хяганат, баглуур-хялганат-таанат ургамалжилттай. Тус талбайд говийн хялгана, зүүнгарын хазаар өвс - *Gleistogenes songorica*, Шар хотир *Zygophyllum xanthoxylon*, Зараа таар - *Nanophyton erinaceum*, Бунгийн харгана - *Saragana bungei*, говийн хазаар өвс, хүйтсэг агь, саваан булган сүүл,

³ Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан

⁴ Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан

таана, хөмүүл, баглуур, бударгана голлосон хээрийн ба цөлөрхөг хээрийн ургамал бүхий цав толгодот тал газар тархах бөгөөд түүний дээрх ургамлын бүрхэц сийрэг тул цулгуй нүцгэн газар ихтэй гадаргийн чулуулаг бүрхэвч 15-80 процент, ургамал бүрхэц нь сийрэг 10-20 процент. Зуны чийгтэй байх богино хугацаанд хөрсний биологийн үйл явц идэвхждэг. Ургамалшил ерөнхийдөө сийрэг боловч тэжээлийн сайн чанартай ургамлаар нилээн баялаг учир бэлчээрийн багагүй ач холбогдолтой юм.

Амьтны аймаг. Төсөл хэрэгжих нутагт *туурайтнаас*: хамгийн их тархсан нь цагаан зээр юм. Түүнчлэн хар сүүлт, аргаль, хулан, *жигүүртнээс*: тас, бүргэд, сар, элээ, хэрээ, харцага, ногтруу, шаазгай, хулан жороо, шар шувуу, өвөөлж, тоодог, тогоруу, *хэвлээр явагчдаас*: могой, гүрвэл, мэрэгчдээс сохор номин, шар сүүлт, бозлог, алаг даага, *махчин амьтадаас* үнэг, хярс, өмхий хүрэн, мануул, бага хэмжээгээр чоно, *шавж идэштнээс*: дэлдэн зараа зэрэг амьтад тохиолдоно. Түүнээс гадна нүүдлийн шувууд хавар, намарт тохиолдох нь цөөнгүй байдаг. Амьтан судлаач Ж.Пунцагдулам төсөл хэрэгжих Айраг сумын нутагт 443 зүйл шавж, 5 зүйл мөлхөгч, 53 зүйл шувуу, 19 зүйл хөхтөн амьтаны зүйлийг бүртгэсэн байна. Энэ нутагт хээр, цөлөрхөг хээрийн бүсэд дасан зохицсон амьтад амьдарч байна. Биологийн олон янз байдал нь амьдрах орчны хувьд цөл ба сөөгт газар гэсэн зонхилох хэлбэрт хамаарна.

Тусгай хамгаалалттай газар нутаг

УТХГН. Төсөл хэрэгжих Айраг сумын хэмжээнд Улсын тусгай хамгаалалтанд авсан Цагаан дэлийн агуй ДГ, хэсэгчилэн хамаарах Их нарт БНГ байна.

ОНТХГН(сумын болон аймгийн). Дорноговь аймгийн Айраг сумд орон нутгийн тусгай хамгаалалттай нийт 33 газар Байгаль орчны мэдээллийн санд <https://eic.mn/> бүртгэгдсэн байгаагаас сумын ангилалд 30, аймгийн ангилал 3 газар хамаарна. MV-008469 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд хамгийн ойр байрлах Алтад ОНТХГН-ийн хилийн зурвас хүртэл 180 гаруй метрийн зайтай болохыг Байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тодорхойлсон байна.

Түүх, соёлын өв. MV-008469 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд 2020 онд МУ-ын ШУА-ын Палеонтологийн хүрээлэнгийн судалгааны баг Палеонтологийн нөөц баялгийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Судалгааны талбайд дунд девоны насны Цагаан-Өндөр бүрдлийн боржин, боржин-сиенит, кварц хайлуур жоншны судлын биет, адамеллит, биотитот, биотит-эвэрхуурмагт боржин-диорит, ховроор кварцат-сиенит байгааг илрүүлж, дээрх интрузив чулуулаг болон орчин үеийн сэвсгэр хурдас чулуулгаас эртний шим ертөнцийн олдвор илрээгүй болох дүгнэлтийг гаргасан.

Улаанбаатар их сургуулийн Түүх, Археологийн тэнхимийн судлаачид 2020 онд Археологийн авран хамгаалах хайгуул, тандалт судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд монгол булш 2 нийт 2 дурсгал илэрснийг баримтжуулан бүртгэсэн.

Дурсгал 01. Хайгуулын талбайн төв хэсэгт нэг монгол булш байна. Энэ дурсгал нь дугуй дугуй хэлбэрийн овгор чулуун дараастай. Голч 4м. Байршил: 45°46'10.60"N 109°23'25.80"E

Дурсгал 02. Өмнөх дурсгалаас баруун хойш 100 м зайд нэг монгол булш байна. Энэ дурсгал нь дугуй дугуй хэлбэрийн овгор чулуун дараастай. Голч 3м. Байршил: 45°46'13.20"N 109°23'22.50"E. "Дурсгал 02" дугаартай дурсгал ашиглалтын талбайн хойд захад 50 м зайд байрлах учир нөлөөллийн талбайд тооцон бүртгэсэн.

Археологийн хайгуул судалгааг газрын хөрсөн дээр байх дурсгалт зүйл дээр тулгуурлан илрэн олдсон дурсгалын судалгаанд үндэслэн хийдэг. Газрын хөрсөн доор түүх-соёлын дурсгал, чулуун зэвсгийн үеийн соёлт давхарга, булш оршуулга байгааг үгүйсгэх аргагүй. Тиймээс цаашид “Би Ти девелопмент” ХХК нь талбайдаа ашиглалт хийх тохиолдолд хөрс шорооны ажлын явцад түүх-соёлын дурсгал илрэн олдвол нэн даруй, зохих хууль ёсны дагуу мэргэжлийн байгууллагад хандан хамтран ажиллах зөвлөмжийг өгсөн.



Зураг 6. “Өмнөт хар айраг” нэртэй MV-008469 талбайн дурсгал

Нийгэм, эдийн засаг. Төсөл хэрэгжих Айраг сум нь нийт 4 багтай бөгөөд MV-008469 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Өмнөд Хар-Айрагийн хайлуур жоншны орд” нь засаг захиргааны хувьд Сайн-Ус багийн нутагт хамаарагдана. Айраг сум нь Дорноговь аймгийн төв Сайншанд сумаас баруун хойш 124 км, Улаанбаатар хотоос зүүн урагш 330 км-т төмөр замын дагуу байрладаг. Айраг сумын төв нь төсвийн 7 байгууллага, төрийн өмчит 3 нэгж, тусгай зөвшөөрөлтэй аж ахуй 7, патентаар үйл ажиллагаа явуулдаг 47 байгууллага байна. Тус суманд 320 хүүхдийн суудалтай ЕБСургууль, 50 ортой дотуур байр, 15 ортой хүн эмнэлэг, 75 ортой хүүхдийн цэцэрлэг, 100 суудалтай соёлын төв үйл ажиллагаа явуулдаг. Дэд бүтцийн хувьд төвийн эрчим хүчинд холбогдсон, үүрэн телефоны үйлчилгээ нэвтэрсэн. Нийслэл Улаанбаатар хот болон Дорноговь аймгийн төвтэй төмөр зам, авто замаар холбогдсон томоохон сум юм.

Айраг сумын онцлог. Айраг сумын төв нь Монгол Оросын хувь нийлүүлсэн Төмөр замын зангилаа байрлаж, үйл ажиллагаа явуулж байгаагийн зэрэгцээ, Онцгой байдлын ерөнхий газрын харъяа шатахууны нөөцийн салбар, Аврах гал унтраах 23 дугаар анги, 110/35/10 кВт-ын цахилгаан дамжуулах дэд станц зэрэг томоохон аж ахуйн нэгж байгууллагууд байрлаж үйл ажиллагаагаа явуулдаг. Хүн ам олноор төвлөрсөн харьцангуй хотожсон сум юм. Энэ нөхцөл нь хүн амын шилжилт хөдөлгөөний тогтвортой байдалд эерэгээр нөлөөлж байна. Хүн амын механик өсөлтөөс шалтгаалан Айраг сумын төвийн суурьшлын бүс тэлэн хөгжиж байна.

2019 оны жилийн эцсийн статистикийн мэдээгээр Айраг сумын суурин хүн амын тоо 3714, насны ангиллаар авч үзвэл 0-14 насны хүүхэд 1128, хөдөлмөрийн насны иргэн 2334, тэтгэврийн насны 60-аас дээш насны иргэн 252 байжээ. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд бүртгэлтэй ажилгүй иргэн 20, нийт ажилгүй иргэдийн 80 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгааг боловсролын түвшингээр нь авч үзвэл 13 хувийг дээд, 4 хувийг тусгай дунд, 61 хувийг бүрэн дунд, 16 хувийг бүрэн бус дунд, 6 хувийг бага буюу боловсролгүй хүмүүс тус тус эзэлнэ. Айраг сумын хэмжээнд нийт 57 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж 20.7 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж улсад 363.5 сая.төг, аймагт 163.4 сая.төг, орон нутагт 93.1 сая.төг, нийт 620.0 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 733. сая.төг байгааг өнгөрсөн мөн үетэй харьцуулахад 122.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн даатгалын сангийн зарлага мөн 110.9 сая.төгрөгөөр нэмэгджээ. Хөдөө аж ахуйн хувьд Айраг сумын хэмжээнд малчдын тоо 545 байгаагаас дийлэнх хувийг 35-59 насны иргэд эзэлж байна.

Малтай болон малчин өрхийн нийгмийн ахуйн үзүүлэлтүүд жилээс жилд өсөх хандлагатай байна. Тухайлбал, цахилгаантай малчин өрх нийт малчдын 84.5%, телевизортой 77.2%, автомашинтай 62.1%, мотоциклтой 70.9%, гар утастай малчин өрх 100% байна. Энэ нь малчин өрхийн нийгмийн үзүүлэлтүүд жилээс жилд сайжирч, нийгмийн хөгжлийн дагуу хувьсан өөрчлөгдөж буйг харуулж байна.

1.3 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг Магадлан жагсаах Матрицийн аргыг ашиглан тодорхойлов. Төслийн болзошгүй нөлөөллийг үнэлэхдээ түүний үйлчлэлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг болох агаар, газрын гадарга, түүхий хэвлий, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, газрын доорх ус, нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэндийг хамруулан нөлөөллийн үнэлгээг доорх алхмуудаар гүйцэтгэв. Үүнд:

- Төслийн байгаль орчин, нийгмийн болзошгүй сөрөг нөлөөллүүдийн цар хүрээ, эрчим, хугацаа, шинж чанарыг тодорхойлж, тоон ба чанарын шинжилгээ хийх;
- Болзошгүй сөрөг нөлөөллүүдийг төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний мэдээлэлд буулган судалж, сөрөг нөлөөллийн тархалт, үр дагаврыг үнэлэх

Хүснэгт 12. Төслөөс байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

Нөлөөлөгч	хэлбэр			хугацаа			чиглэл		эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Дунд хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1.Байгаль, экосистемийн өөрчлөлт											
Газрын доорх усны өөрчлөлт		x				x		x			x
Хөрсний элэгдэл, эвдрэл	x					x		x	x		
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт		x						x			x
Бичил уур амьсгалын өөрчлөлт		x				x		x			x
2.Байгаль орчны ашиглалт											
Газрын доорхи усны чанар, нөөц	x	x				x		x			x
Гадаргын усны чанар, нөөц		x						x			x
Агаарын бохирдол	x			x			x				x
Хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдол	x					x		x	x		
Ургамлан нөмрөгийн талхагдал	x					x		x		x	
Дуу чимээ	x			x			x				x
3.Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палентлогийн олдвор											
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	x						x				x
Ландшафтын хэлбэр өнгө төрх өөрчлөгдөх	x						x				x
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	x					x		x		x	
Түүх, соёлын дурсгалд зүйлд нөлөөлөх		+									+
4.Эдийн засаг, нийгмийн асуудал											
Орон нутгийн иргэдийн орлого нэмэгдэх	+					+	+				+
Аялал жуулчлал хөгжих	+					+	+			+	
Ажлын байр нэмэгдэж ажилгүйдлийг бууруулахад дэмжлэг болох	+					+	+				+
Өрхийн амьжиргааны түвшин дээшлэх, орлого нэмэгдэх	+					+	+				+
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+					+	+			+	
5.Бусад нөлөөлөл											
Хог хаягдлыг зохисгүй газар хадгалах, ил задгай хаях, удаан хугацаагаар зайлуулахгүй байх зэргээс орчин бохирдох, эвгүй үнэр гарах, хөрс, ургамлан нөмрөг бохирдох, салхиар туугдан орчин тархах	x	x				x	x			x	
Олон салаа зам гарах	x			x				x			x
Хөл хөдөлгөөн ихсэх	x				x						x
Галын аюулгүй байдал алдагдах, гал түймэр гарах	x			x		x	x		x		

Байгалийн гамшиг болох /салхи, шуурга, аянга цахилгаан, газар хөдлөлт гэх мэт/		x		x		x		x	x		
Нийт	13/5	7/1	0	5	3	10/5	6/5	11	4	3/2	11/3

Тайлбар: x – сөрөг нөлөөлөл, + – эерэг нөлөөлөл

Дүгнэлт. Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших хайлуур жоншны ордыг “Би Ти Девелопмент” ХХК нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулах бөгөөд ашиглалтын явцад байгаль орчны төлөв байдал болон нийгэм, эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн үнэлгээг *Магадлан жагсаах* аргаар гаргахад: Уурхайн ашиглалтын явцад үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүд шууд болон шууд бус замаар, ихэнх нь урт хугацаатай, эрчмийн хувьд харилцан адилгүй нөлөөллүүд байна. Тодруулбал:

Шууд нөлөөлөл: Төслийн явцад байгалийн нөөц болох ашигт малтмал ашиглах, геологийн тогтоцын өөрчлөлт, ландшафтын төрх байдал, байгалийн унаган төрх өөрчлөгдөх, хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэх, ургамлан нөмрөг өөрчлөгдөх, цэнгэг усны нөөц ашиглах, төслийн явцад ашиглагдах техник, тоног төхөөрөмжөөс бохирдуулагч бодис агаар мандалд ялгаруулах, дуу чимээ үүсэх зэргээр шууд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй. Мөн өрөмдлөг, тэсэлгээний ажилтай холбоотой доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх нөлөөлөл байж болзошгүй. Харин нийгэм, эдийн засагт шинээр ажлын байр бий болох шууд эерэг нөлөөлөлтэй байна.

Шууд бус нөлөөлөл: Төслийн явцад газрын доорх ус болон хөрс бохирдох, хөрс доройтох, цөлжих, байгалийн зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтох зэргээр шууд бус, дам нөлөөлөл үзүүлж болзошгүй. Мөн аюулт үзэгдэл тохиолдох, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдал алдагдсанаас хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсч болзошгүй.

Нийгэм, эдийн засагт ажлын байр шинээр бий болсоноор өрхийн орлого нэмэгдэх, амьжиргааны түвшин дээшлэх, ядуурлыг бууруулахад дэмжлэг болохоос гадна эдийн засгийн эргэлтээр татвар хураамжаар дамжин орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх, дэд бүтэц сайжрих олон талын ач холбогдолтой. ТЭЗҮ-д тусгагдсанаар улс, орон нутгийн төсөвт нийт 10.92 тэрбум төгрөгний татвар, төлбөр оруулна.

Хугацааны хувьд ихэнх нөлөөлөл нь төслийн цар хүрээнээс хамаарч урт хугацаанд багтаж байгаа боловч нөлөөллийн үргэлжлэх хугацаа богино нөлөөллүүд байна. Үүнд: газрын доорх ус, хөрс бохирдох, агаар мандалд бохирдуулагч хий ялгарах, хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэх зэрэг. Эдгээр болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах бүрэн боломжтой тул хугацааны хувьд богино нөлөөлөл гэж үзлээ.

Нөлөөллийн эрчмийн хувьд харилцан адилгүй бөгөөд бага нөлөөлөлд ихэнхдээ хугацааны хувьд богино нөлөөлөл хамрагдаж байна. Тухайлбал: газрын доорх ус болон хөрс бохирдох, хөрс доройтох, цөлжих, ургамлан нөмрөг өртөх, зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтох, бохирдуулагч бодис агаар мандалд ялгарах. Мөн уурхайн ашиглалтын явцад технологийн ус шаардахгүй бөгөөд зөвхөн ажилчдын унд-ахуйн ус хэрэглээ, тоосжилт дарах зорилгоор ус ашиглана. Иймээс цэвэр усны нөөцөд нөлөөлөл бага байна, дунд нөлөөлөлд хөрсөн бүрхэвч эвдрэх, дуу чимээний бохирдлыг орууллаа. Харин хүчтэй нөлөөлөлд геологийн тогтоцын өөрчлөлт, ландшафтын төрх байдал өөрчлөгдөх, ашигт малтмал ашиглах зэрэг уул уурхайн үйл ажиллагаанд хамгийн ихээр өртөж, төрх байдал нь өөрчлөгдөж доройтох хэсгүүдийг хамааруулж авч үзлээ.

1.4 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, уурхайн орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг болно.

2024 оны Байгаль орчны менежментийг төлөвлөгөөг БОАЖ-ын сайдын 2019 оны 10-р сарын 29 өдрийн А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу, мэргэжлийн байгууллагын боловсруулж, батлуулсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн боловсруулав.

БОАЖ-ын сайдын 2019 оны 10-р сарын 29 өдрийн А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу:

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө
5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
6. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө
7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө
8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
9. БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
10. БОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө гэсэн агуулгын хүрээнд хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхой тусгасан болно.

Хүснэгт 13. 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын сайдын 2019 оны 10-р сарын 29 өдрийн А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж, нийт 6 сая 550 мян.төгрөг зарцуулахаар төсөвлөв.

Хүснэгт 14. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал, төгрөгөөр

№	Агуулга	Нийт зардал, төг
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1 000 000
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1 525 000
3.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1 100 000
4.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал
6.	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	700 000
7.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	300 000
8.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1 125 000
9.	БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	400 000
10.	БОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	400 000

*Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт орших MV-008469 тоот
“Өмнөт Хар-Айрагийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах” төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

1.5 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 15. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Агаарын чанар	Агаарын чанарын хяналт шинжилгээг хэрэгжүүлэх	Төслийн талбай, түүний орчин	удаа	ОХШХ-ийн зардалд тусгасан	2	ОХШХ-ийн зардал тусгасан	Уурхайн ашиглалтын явцад	Агаарын тухай хуулийн 9.1.4 MNS 4585:2016
		Агаар бохирдуулсны төлбөр хураамжийг төлөх	Машин механизм тус бүр	удаа	-	1	300000	Уурхайн олборлолтын явцад	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9.3
2	Агаарын тоосжилт	Шүүрлийн усыг уурхайн дотоод тээвэрлэлтийн зам, овоолгоос үүсэх тоосжилтыг дарж усалгаа хийж сайжруулах арчилан тордох	Зам талбай, Овоолго	удаа	-	Тухай бүр	-	Хүдэр ачиж, тээвэрлэх явцад	Агаарын тухай хуулийн 9.1.7 Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 6.1.5
Гадаргын болон газрын доорх ус									
3	Цэвэр усны нөөц	Ус ашиглах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл гаргуулж гэрээ байгуулах	Ус ашиглалт	удаа	100000	1	300000	Уурхайн олборлолт явуулахын өмнө	Усны тухай хуулийн 28.4; 28.6; 28.11 заалтууд
		Усны гэрээ дүгнэсэн тайлан мэдээг төрийн захиргаанд хүргүүлэх	Шүүрлийн ус	удаа	200000	1	200000	Уурхайн олборлолтын явцад	Усны тухай хуулийн 30.1.5, ЗГ-н 2013 оны 326, 327-р тогтоол
4	Усны чанар	Шүүрлийн уснаас шинжилгээ хийлгэх	Шүүрлийн цооногоос	удаа	ОХШХ-ийн зардалд тусгасан	1-4	ОХШХ-ийн зардал тусгасан	Уурхайн ашиглалтын явцад	MNS 0900:2018

*Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт орших MV-008469 тоот
“Өмнөт Хар-Айрагийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах” төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
5		Уст цэг болон булаг шандын эхийг цэвэрлэх	Уурхайн ойр орчим	удаа	Үйл ажиллагааны зардал	1-2	Үйл ажиллагааны зардал	Уурхайн ашиглалтын явцад	
6	Газрын доорх усны бохирдол	Хаягдал усны дүгнэлт гаргуулж, орон нутагдаа гэрээ байгуулж, төлбөр төлөх	Хаягдал усны шугамын гаргалгаа дээр	удаа	-	1	200000	Уурхайн ашиглалтын явуулахын өмнө	БОАЖ-ын сайдын 2013 оны А-156 дугаар тушаал Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам
Хөрсөн бүрхэвч, газрын гадарга									
7	Хөрс, газрын гадаргын элэгдэл, эвдрэл	Уурхайн орчмын эмх замбараагүй шороог тэгшлэн хэлбэржүүлэх	Уурхайн лицензийн талбай	га	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан	0.5	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан	Уурхайн олборлолтын явцад	MNS 5917:2008
8	Хөрс, газрын гадаргын бохирдол, доройтол	Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, тусгай зориулалт бүхий цэгт цуглуулах	Уурхайн тосгоны ойр орчин	удаа	Хог хаягдлын менежментийн зардалд тусгасан	Тухай бүр	Хог хаягдлын менежментийн зардалд тусгасан	Уурхайн ашиглалтын явцад	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.1, 10.2.2, 10.2.8,
		Хөрсний хяналт мониторингийн ажлыг хэрэгжүүлэх	Төслийн талбайн мониторингийн цэгт	удаа	ОХШХ-ийн зардал тусгасан	2	ОХШХ-ийн зардал тусгасан	Уурхайн олборлолтын явцад	Лабораторийн арга зүй, MNS 5850:2019

*Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт орших MV-008469 тоот
“Өмнөт Хар-Айрагийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах” төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
Ургамлан нөмрөг									
9	Ургамлан нөмрөг талхлагдах	Уурхайн тосгоны хүний хөлд ихээр өртөх зам талбайг тордох	Уурхайн тосгоны ойр орчин	удаа	Нөхөн сэргээлтгүй төлөвлөгөөнд тусгасан	0.2	Нөхөн сэргээлтгүй төлөвлөгөөнд тусгасан	Уурхайн ашиглалтын явцад	MNS 6773:2019 MNS 6808:2019
		“Тэр бум мод” тарих хөтөлбөрийн хүрээнд мод тарих талбайг бэлтгэх	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд	га	Нөхөн сэргээлтгүй төлөвлөгөөнд тусгасан	0.1	Нөхөн сэргээлтгүй төлөвлөгөөнд тусгасан	Уурхайн олборлолтын явцад	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4
Амьтны аймаг									
10	Зүйлийн олон янз байдал	Олборлолтын талбайд мал амьтан нэвтрэхээс сэргийлж, байнгын хараа хяналт тавих	Олборлолтын талбай	удаа	Үйл ажиллагааны зардал	1	Үйл ажиллагааны зардал	Уурхайн олборлолтын явцад	Амьтны тухай хуулийн 6.1.7 -
Нийт зардал, төг								1 000 000	

1.6 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 16. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Техникийн нөхөн сэргээлт	Гар аргаар олборлолтонд өртсөн талбайг дүүргэх	га	0.5	-	1000000	Уурхайн олборлолтын явцад	MNS 5917:2008
2	Биологийн нөхөн сэргээлтэд бэлтгэх	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай дээр биологийн нөхөн сэргээлт хийх талбайг бэлтгэх	га	0.1	-	525000	Уурхайн олборлолтын явцад	Мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу
Нийт зардал, төг						1525000		

1.7 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд уул уурхайн үйл ажиллагаагаар эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх ажилд орон нутгаас санал авсаны үндсэн дээр өөрийн ашиглалтын лицензийн талбайн ойр орчны эзэнгүй орхигдсон, нөлөөлөлд өртөж эвдэрсэн нийт 23.8 га газарт 5 жилийн хугацаанд техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн. Үүнээс эхний 2022 онд 6.8 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн. 2023 онд 2 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдэнэ.

Хүснэгт 17. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх	Мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэх, объёмыг тодорхой болгох	Уурхайн талбайн ойр орчин		-	200000	Уурхайн ашиглалтын өмнө	-
2		Техникийн нөхөн сэргээлт хийх	Уурхайн талбайн ойр орчин	1 га	Үйл ажиллагааны зардалд тусгах		Уурхайн ашиглалтын явцад	Дорноговь аймгийн Айраг сумын 2-р баг, 19-р илрэл

*Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт орших MV-008469 тоот
“Өмнөт Хар-Айрагийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах” төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

								нэртэй талбай
3	Ногоон байгууламжийн талбай хэмжээг нэмэгдүүлэх	Ашиглалтын талбайд мод тарих	Чацаргана	ш	50	250 000	Уурхайн ашиглалтын явцад	MNS 5917:2008
			Хайлс	ш	250	300 000	Уурхайн ашиглалтын явцад	Агротехнологийн картын дагуу
			Улиас	ш	250	350 000		
Нийт зардал,төг						1 100 000		



Зураг 7. Нөхөн сэргээлт хийх талбайн сансарын зураг

1.8 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

MV-008469 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай жоншны ордын 76.08 га талбай, уурхайн олборлолтын нөлөөлөлд өртөх 3.2 га талбайн хэмжээнд нөлөөлөлд өртөх айл өрх байхгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй гэж үзэв.

1.9 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

MV-008469 тусгай зөвшөөрлийн талбайд хийсэн мэргэжлийн байгууллагын судалгаагаар Палеонтологийн олдвор илрээгүй, Археологийн нийт 2 дурсгал (уурхайн ашиглалтын талбайд **Дурсгал 01**, уурхайн ашиглалтын талбайн хойд захад 50м зайд байрлах нөлөөллийн талбайд **Дурсгал 02**) бүртэгдсэн.

Хүснэгт 18. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Археологийн дурсгал	Археологийн дурсгалыг хөндөхгүй байх, ажилчид болон төслийн холбогдох хүмүүст мэдээлэл өгч танилцуулах	Дурсгал 01 Дурсгал 02	1-2 удаа	-	-	Уурхайн олборлолт явуулахын өмнө	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
2	Археологийн дурсгал, Палеонтологийн дурсгал	Газар шорооны ажлын явцад соёлын биет өв илэрсэн тохиолдолд ажлаа зогсоож, холбогдох байгууллагад нэн даруй мэдэгдэх, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах	Уурхайн малталтууд	2	Үйл ажиллагааны зардал		Уурхайн олборлолтын явцад	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3
Нийт зардал, төг					Үйл ажиллагааны зардал			

*Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт орших MV-008469 тоот
“Өмнөт Хар-Айрагийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах” төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

1.10 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 19. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангах	Нийт ажилчдын хөдөлмөрийн нөхцөл	80 хүн	Үйл ажиллагааны зардал		Уурхайн олборлолтын явцад	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 15-р зүйл
2	Галын аюулгүй байдал	Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг байршуулах, тэдгээрийн бэлэн байдлыг хангах	Уурхайн тосгон, ТМ-ын агуулах	2 ш	200000	400000	Уурхайн ашиглалт явуулахын өмнө	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.6
		Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг холбогдох газраар гаргуулах	Барилга байгууламж	1 удаа	-	100000	Уурхайн олборлолт явуулахын өмнө	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 23.3
3	Химийн бодисын хадгалалт, ашиглалт	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг ханган нийлүүлэгчээс худалдан авч, аюулгүй байдлыг ханган тээвэрлэх	Тээвэрлэлт	Тухай бүр	Үйл ажиллагааны зардал		Уурхайн олборлолтын явцад	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай 14.1
		Агуулахаас тэсрэх материалыг ажлын талбай руу тогтоосон маршрутын дагуу тээвэрлэх	Уурхайн дотоод тээвэрлэлт	Тухай бүр, тогтмол	-	-	Уурхайн ашиглалтын явцад	Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн 147 ⁵

⁵ Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолын хавсралт

*Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт орших MV-008469 тоот
“Өмнөт Хар-Айрагийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах” төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
		Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн ашиглалт зарцуулалтын бүртгэл хөтөлж, холбогдох байгууллагад тайлагнах	Бортогот тэсрэх бодис эмульс	1 удаа	-	200000	Уурхайн ашиглалтын явцад, МХЕГ болон ЦЕГ, ТЕГ	“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн ⁶ 597-615
4	Осол аваар	ХАБЭА-н сургалт зохион байгуулах	Нийт ажилчдыг хамруулна	1 удаа	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан		Уурхайн ашиглалтын явцад	НХХ-ийн сайдын 2008 оны 127-р тушаал, ХАБЭА-н сургалт зохион байгуулах, шалгалт авах журам
5		Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Үйл ажилгааны туршид		-		Уурхайн ашиглалтын явцад	Үйл ажилжилгааны аюулгүй байдал
Нийт зардал, төг						700000		

⁶ Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолын хавсралт

*Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт орших MV-008469 тоот
“Өмнөт Хар-Айрагийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах” төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

1.11 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 20. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Ахуйн хатуу хог хаягдал	Орон нутагтай хог хаягдал ачиж зайлуулах гэрээ байгуулах, хог хаягдлыг тогтмол зайлуулж, үйлчилгээний хөлсийг тухай бүр төлөх	Хатуу хог хаягдал	Зайлуулсан тухай бүр	Гэрээний дагуу	-	Үйл ажиллагааны зардал	Уурхайн ашиглалтын явцад	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.3, 10.2.7
2	Ахуйн шингэн хаягдал	Хаягдал ус зайлуулах дүгнэлтийг Умард говийн гүвээт- Халхын дундад талын сав газрын захиргаас гаргуулах	Ахуйн бохир ус	удаа	-	1	200000	Уурхайн олборлолт явуулахын өмнө	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 4.1, Усны тухай хуулийн 24.2
		Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ орон нутагтай хийж, хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл гаргуулах	Ахуйн бохир ус	удаа	50	1	100000	Уурхайн олборлолт явуулахын өмнө	Усны тухай хуулийн 24.2
Нийт зардал, төг							300000		

*Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт орших MV-008469 тоот
“Өмнөт Хар-Айрагийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах” төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

1.12 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр


Хүснэгт 21. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
Агаар орчин								
1	Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), Азотын давхар исэл (NO ₂) Нийт тоосонцор	Ангилан ялгах хэсгийн орчинд <i>нийт 1 цэгт</i>	Уурхайн олборлолтын явцад	2 удаа	100000	200000	Зөвшөөрөлтэй лаборатораар хийлгэх	MNS 4585:2016
Хөрс								
2	Хөрсний агрохимийн үзүүлэлт	Төслийн талбайн мониторингийн цэгт <i>нийт 2-3 цэгт</i>	Уурхайн олборлолтын явцад	2 удаа	45000	270000	-	MNS 3298:1991 MNS 3297:2019
3	Хүнд металлын бохирдол	Олборлолтын талбай болон хүдрийн овоолго <i>нийт 1-2 цэгт</i>	Уурхайн олборлолтын явцад	2 удаа	100000	200000	Шинжилгээний үр дүнгээр хамаарч давтамжийн тоог нэмэгдүүлнэ.	MNS 5850:2019 MNS 3298:1991
Ус								
4	Ерөнхий химийн үзүүлэлтүүд	Шүүрлийн усанд <i>нийт 1 цэгт</i>	Уурхайн олборлолтын явцад	2-4 удаа	50000	255000	-	MNS 0900:2018
5	Хүнд металл / <i>нийт 20 элемент/</i>	шүүрлийн усанд	Уурхайн олборлолтын явцад	2 удаа	100000	200000	Шинжилгээний үр дүнгээр хамаарч давтамжийн тоог нэмэгдүүлнэ.	MNS 0900:2018 MNS ISO 17025:2018

*Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт орших MV-008469 тоот
“Өмнөт Хар-Айрагийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах” төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
Ургамал								
6	Ургамлын зүйлийн бүрдлийг ажиглах	Төслийн талбайд	6-8-р сард (Ургамлын цэцэглэлт ба үр жимс боловсрох үед)	1 удаа	-	Үйл ажиллагааны зардал	Уурхайн олборлолтын явцад	Ажиглалт
Амьтан								
7	Төслийн талбай, түүний ойр орчинд тааралдах амьтдын зүйлийн бүрдлийг ажиглах	Төслийн талбай, түүний ойр орчин	Уурхайн олборлолтын явцад	1-ээс доошгүй удаа	-	Үйл ажиллагааны зардал	Уурхайн олборлолтын явцад	Ажиглалт
Нийт зардал, төг						1 125 000		

Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших “Би Ти Девелопмент” ХХК-ийн MV-008469 тоот ашигт малтмал ашиглах ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Өмнөд Хар-Айраг” нэртэй хайлуур жоншны талбайн Хяналт-мониторингийн цэгийн байршлын зураг



Таних тэмдэг



MV-008469 ашиглалтын талбайн хил

Хяналт мониторингийн байршлын солбилцол:

Усны ерөнхий хими, микробиологийн дээжлэлт
109° 23' 53.17" E. 45° 46' 9.04" N

Усны хүнд металлын дээжлэлт
109° 23' 14.38" E. 45° 46' 08.72" N

Хөрс агрохими дээжлэлт
109° 22' 38.98" E. 45° 46' 6.28" N
109° 24' 6.82" E. 45° 46' 1.07" N

Хөрсний хүнд металлын дээжлэлт
109° 22' 56.37" E. 45° 46' 11.16" N

Агаарын сорьц
109° 23' 32.74" E. 45° 46' 10.28" N

*Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт орших MV-008469 тоот
“Өмнөт Хар-Айрагийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах” төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

1.13 БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 22. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь												Хариуцсан албан тушаалтан	Тайлбар		
			2022 он															
			I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII				
1.	БОМТ-ний биелэлтийн тайланг Дорноговь аймгийн Байгаль орчны газарт хүргүүлж, ажлын хэсгээр дүгнүүлэх	200000															Хариуцсан албан тушаалтан, байгууллагын төлөөлөл	БОАЖ-ын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тушаал
2	Нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах	200000																Ашигт малтмалын тухай хуулийн 42.1
Нийт зардал, төг		400000																

1.14 БОМТ-ний биелэлтийг холбогдох газарт нь тайлагнах төлөвлөгөө

2024 оны БОМТ-г ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор холбогдох журмын дагуу гаргаж, харьяалагдах аймгийн Байгаль орчны газарт хүргүүлж, аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт газар дээр нь шалгуулж, дүгнүүлнэ.

Хүснэгт 23. БОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцсан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Дорноговь аймгийн Байгаль орчны газар	Тайланг хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр албан бичгийн хамт хүргүүлнэ.	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайлан	11-р сарын 01-ний дотор	100000	Байгаль орчны ажилтан, байгууллагын төлөөлөл	Дорноговь аймаг
Дорноговь аймгийн Засаг Дарга 11 дүгээр сарын 01-ний дотор БОМТ-ний биелэлтийн тайланг газар дээр нь хянах, дүгнэх ажлын хэсэг байгуулна.							
2	Дорноговь аймгийн ЗД-ын томилсон ажлын хэсэг	Газар дээр дүгнэнэ.	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн	11 дүгээр сарын 30-ны дотор	300000	Байгаль орчны ажилтан,	Дорноговь аймгийн Айраг сум

*Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт орших MV-008469 тоот
“Өмнөт Хар-Айрагийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах” төслийн
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
			талаар танилцуулна.			байгууллагын төлөөлөл	
Нийт зардал, төг					400000		